



**МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.02.25 № 01/09 УАГ/САГ/2013/21/СТГА-ТОВГ  
Зөрчлийг арилгуулах тухай

ЧИНГИСХААН ОЛОН УЛСЫН НИСЭХ  
БУУДЛЫН ДАРГА Л.БЯМБАСҮРЭН,  
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ  
Х.БАЯРМАА НАРТ

Үндэсний Аудитын газрын 2012 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Чингисхаан олон улсын нисэх буудлын 2012 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Тушаал, шийдвэргүйгээр касснаас 18.3 сая төгрөг олгосон нь НББ-ийн тухай хуулийн 7.7-д “Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн,
- 2012 оны 11 сард эхний 3 улирлын ажлын үр дүнгийн шагнал нэрээр ажилтан бүрийг 500.0 мянган төгрөгөөр, 12 сард шинэ жилийн баярыг тохиолдуулан ажилтан бүрийг 500.0 мянган төгрөгөөр нийт 648.5 сая төгрөгөөр шагнасан нь 2012 оны батлагдсан зардлыг хэтрүүлсэн бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16.3-д “үйлдвэрийн үйл ажиллагааны үр дүнд олсон ашгаас эрх бүхий байгууллагаас баталсан нормативт хэмжээгээр өөртөө үлдээж захиран зарцуулах” гэснийг зөрчсөн;
- Гэрээ байгуулахгүйгээр 16 компаниас 164.7 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдаж авсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33.2.2-д “техникийн болон бусад нөхцөл шаардлагыг хангаж байгаа хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид энэ хуулийн 29.1-д заасны дагуу гэрээ байгуулах эрх олгох” гэсэн заалтыг зөрчсөн

“Төрийн аудитын тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 1-ийн 12-т “Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх”, Монгол улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1 дүгээр заалтыг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

070022

тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1.1 дүгээр заалтыг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

Тушаал шийдвэргүй, бүрдэл дутуу баримтаар олгосон 18.3 сая төгрөгийн ажил гүйлгээний холбогдох баримт материал, тайлан тооцоог бүрдүүлэх, 648.5 сая төгрөгийн үр ашиггүй шагналын зардлыг дахин давтахгүй байх, гэрээ байгуулахгүйгээр бараа, ажил, үйлчилгээг худалдан авдаг зөрчлийг арилган биелэлтийг 2013 оны 4 дүгээр сарын 25-ны дотор багтаан Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Чингисхаан олон улсын нисэх буудлын дарга Л.Бямбасүрэн, Ерөнхий нягтлан бодогч Х.Баярмаа нарт хариуцуулав.


### АЛБАН ШААРДЛАГА

БИЧСЭН:

Үндэсний аудитын газрын

Ахлах аудитор *И.Туяа* И.ТУЯА

Бодит бүртгэл Аудит ХХК-ийн  
Захирал *З.Ганболд* З.Ганболд



Чингисхаан олон улсын  
нисэх буудлын дарга  
*Л.Бямбасүрэн* Л.БЯМБАСҮРЭН

Ерөнхий нягтлан бодогч  
*Х.Баярмаа* Х.Баярмаа

*Тайлбар*  
(Зоргоор тавигдсан) амьтталцуулаг олгосон 648,5 сая  
төгрөгийн ИМЕТ-ийн баримт 2012 оны 11-р сарын 23-ны  
А/401; 12-р сарын 07-ны А/424 тоот тушаалыг  
үйцэтгэн олгосон байна.

*Х.Баярмаа*